

БНХАУ дахь шинэтгэл

**БНХАУ-ЫН ҮНДЭСТНИЙ  
АВТОНОМИТ РАЙОНУУД ДАХЬ  
ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН  
БАЙДАЛ**

**Ж. Бямбасүрэн**

Одоо Хятадад Өвөрмонгол (ӨМАР), Синьцзян-Уйгур (СУАР), Төвд (ТАР), Нинся-Хотон (НХАР), Гуанси-Жуан (ГЖАР) -ы таван автономит район, үндэстний 31 автономит тойрог, 100 орчим автономит сянь байна. БНХАУ-ын нутаг дэвсгэрийн 60 гаруй хувь, тал газрын 90 хувийг эзэлдэг бөгөөд ашигт малтмал, ой мод, ус, ургамал болон байгалийн бусад баялгийн арвин нөөцтэй эдгээр үндэстний районууд улсынхаа эдийн засгийн бүтээн байгуулалтад чухал үүрэгтэй юм.

1970-аад оны сүүлчээс Хятад орон даяар хэрэгжүүлж эхэлсэн эдийн засгийн шинэтгэлийн бодлого үндэстний районуудад мөн тусгалаа олж, сүүлийн үед тэдгээрийн эдийн засагт зарим нааштай ахиц өөрчлөлт гарч байна. Хөдөөд хийх шинэтгэл голлон явагдсан VI таван жилийн (1981—1985 он) төлөвлөгөөний хугацаанд Хятадын нам, төрөөс үндэстний районуудын эдийн засгийг хөгжүүлэх талаар нэлээд анхаарал тавьж, арга хэмжээ авсны үрээр уг таван жилийн төлөвлөгөөг нийт үндэстний районууд амжилттай биелүүлснээс СУАР, НХАР зэрэг нь нэг жилийн өмнө гол гол үзүүлэлтүүдийг биелүүлсэн бөгөөд энэ таван жилийг «үндэстний районуудын эдийн засгийн хувьд хамгийн сайн үеийн нэг боллоо»<sup>1</sup> гэж үзэж байна. Үндэстний районуудын аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн 1985 онд 80 орчим миллиард юаньд хүрсэн нь (үнийн болон газар нутгийн өөрчлөлтийг тооцохгүйгээр) 1980 оныхоос 58,6% нэмэгдэж, жилийн дундаж өсөлт нь 9,7% буюу түрүүчийн 28 жилийн (1953—1980) дунджаас 6,6%-иар давжээ. Түүний дотор хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн 35,1 млрд. юаньд (тосгоны үйлдвэрийг оруулахгүйгээр) хүрсэн нь 1980 оныхоос 45,2% өсч, жилийн дундаж өсөлт нь 7,7% буюу түрүүчийн 28 жилийн дунджаас 3,5% нэмэгджээ.<sup>2</sup> Гэвч эдгээр нь Хятад улсын хөгжлийн дундаж хурдцаас доогуур, тооны талыг голлосон үзүүлэлт болохыг анхаарах хэрэгтэй юм.

Дээрх үндэстний районууд Хятадын хөдөө аж ахуйн гол түшиц газрын нэг болохын хувьд хөдөөд хийсэн шинэтгэлийн гол арга хэмжээ «өрхийн хариуцлагын систем»-д өргөн хамрагдсан ажээ. Тариалангийн талбай, нийгмийн мал, бэлчээрийг хувь хүн, айл өрхийн мэдэлд шилжүүлж, үйлдвэрлэлийг бие даалган явуулах журмыг тухайн газар орны онцлог, аж ахуйн байдалтай нь уялдуулан хэрэгжүүлж байна. Тухайлбал, БНХАУ-ын мал аж ахуйн том бааз Өвөр Монголд малыг хувь хүнд хариуцуулахдаа тодорхой үнэ, хугацаа тогтоож гэрээлэн олгожээ. Үндэстний районууд газар тариаланг голчлон хувийн аж ахуйн хэлбэрээр хөгжүүлж байгаа бөгөөд тариачдад газрыг 15—20 жил, зарим районд нь бүр 50 хүртэл жилийн хугацаатай хариуцуулан өгч, хүссэн үр тариагаа аль боломжийн аргаар тариалж болохыг зөв-

1 « Жэньминь жибао » 1986. V. 16.

2 «Миньзу туаньзе» 1986. № 8, 22-р тал

шөөрөв. Өрхийн хариуцлагыг гол болгосон гэрээт хариуцлагын системийг үндэстний районуудад өргөн нэвтрүүлснээр тариачид, малчдын үйлдвэрлэл эрхлэх урам зориг, идэвхийг сэргээж, үндэстний районуудын хөдөө аж ахуйг их амжилтад хүргэв гэж хятадын хэвлэлд бичжээ<sup>3</sup>.

Энэхүү хариуцлагын систем нь нэг талаар тариачид, малчдын хөдөлмөрийн идэвхийг өрнүүлж, тухайн газар орны хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг өөд татахад түлхэц өгч чадахуйц шинэ чухал арга хэмжээ мөн боловч нөгөө талаар хувийн өмчтөний үзлийг дэвэргэж хамтын социалист аж ахуйгаас хөндийрүүлэх шимт хөрс болж мэдэх юм. «Хариуцлагын систем»-ийн эцсийн үр дүн чухам юу болохыг одоогоор урьдчилан хэлэхэд төвөгтэй юм.

Үндэстний районууд нь ихэнхдээ аж үйлдвэр сул дорой хөгжсөн, тэдгээрт олон жилийн турш амиа аргацаасан натурал аж ахуйн хэвшил ноёрхож ирсэн нутаг юм. Энэхүү хоцрогдлыг даван туулж, тэдгээрийн эдийн засгийг хөгжүүлэх гол арга зам бол таваарын үйлдвэрлэл, таваарын аж ахуйг хөгжүүлэх явдал гэж Хятадын удирдлага үзэх болж, тиймээс ч энэ асуудалд нэлээд анхаарал хандуулж байна. Уг нутгийн хүн ард газар орны онцлог, эд баялгийн давуутай байдлаа ашиглан тодорхой үйлдвэрлэлийг дорвитой явуулж, бүтээгдэхүүнээ борлуулалтын зах зээлд оруулан нийтийн хэрэгцээнд зориулахад таваарын аж ахуйн гол зорилго орших бөгөөд түүний хөгжилт нь хувийн аж ахуйтан үүсч дэвжих, хятадад одоо ихээхэн уриалан дэмжиж байгаа хөдөлмөрөөрөө баяжин чинээлэгжих»-ийн бодитой хүчин зүйл болж байна. Урьд өмнө мал аж ахуй, газар тариалангийн хязгаарлагдмал ажил хийж байсан хятад биш үндэстний малчид, тариачид бага хэмжээний үйлдвэр, уурхай нээж, тээвэр, худалдаа үйлчилгээ, жуулчлалын ажил хариуцан хувийн болон хамтын үйлдвэрлэл эрхлэх явдал сүүлийн жилүүдэд элбэгшив.

Ийнхүү үндэстний районуудад таваарын үйлдвэрлэл, хувийн аж ахуй хөгжиж эхэлж байгаа нь тухайн нутаг орны үйлдвэрлэлийн бүтэц, зохион байгуулалтад хувиралт гаргаж, ард түмний амьдралд ч зарим нөлөө үзүүлж байна. Хятадын тоо баримтаас үзвэл, өнгөрсөн 5 жилийн сүүлч гэхэд үндэстний районуудад 1 сая 20 мянга гаруй худалдааны байгууллага (төрөл бүрийн аж ахуйн зориулалттай худалдааны байгууллагууд орно) байсан нь 1980 оныхоос 4 дахин нэмэгджээ. Тэдгээрийн жижиглэн худалдаалах бараа гүйлгээний хэмжээ 41,1 миллиард юаньд хүрсэн нь 1980 оныхоос 102,3% нэмэгджээ<sup>4</sup>. VI таван жилийн хугацаанд үндэстний районуудын хот хөдөөд оршин суугчдын бодит орлого жил бүр 5—8% нэмэгдснээс тариачид, малчдынх бүр их байв. Жишээ нь, 1985 онд Өвөр Монголын тариачдын жилийн дундаж цэвэр орлого 360 юань, жилийн дундаж өсөлт нь 140 малчдынх 650 юань, дундаж өсөлт нь -19,6%, Нинсяд тариачдын жилийн дундаж цэвэр орлого 299 юань байсан нь (юмны үнэ нэмэгдсэнийг тооцохгүйгээр) жилд 10% өсчээ<sup>5</sup>. Гэвч хятадын нийт тариачдын орлогын өсөлтөд хараахан хүрэхгүй байна. «Жэньминь жибао»-сонинд мэдээлснээр, 1986 онд Хятад улсын нэг тариачны жилийн дундаж цэвэр орлого 424,05 юаньд хүрсэн бөгөөд дорнод бүсийн тариачдын дундаж орлого 495,6 юань буюу урьд оныхоос 7,1 % өссөн байхад бараг бүхэлдээ хятад биш үндэстний өлгий нутаг-баруун бүсийн тариач-

3 «Миньзу туаньзе» 1986. № 8, 22-р тал

4 Мөн тэнд

5 Мөн тэнд 23-р тал.

дын дундаж орлого 327,9 юань буюу жилд дөнгөж 1,9%-иар өссөн байна. Үүнээс үндэстний районуудын тариачдын бодит орлого, түүний өсөлт ихээхэн доогуур түвшинд байгааг харж болно.

Эдүгээ үндэстний районуудад хувиараа үйлдвэрлэл эрхлэгчид олширч, баяжих явдлыг илэрхий дэмжиж байгаа нь хүн амын дотор өмчийн ялгаа ихэсч, зарим хэсэг нь хэт хөрөнгөжиж бусдын хөдөлмөрийг хөлслөн завших зэрэг нийгмийн сөрөг, хортой үзэгдлүүд үүсч гарах нөхцөл бүрэлдүүлж байна. Жишээ нь, Өвөр Монголын Шилийн гол аймгийн Авгач хошууны Их булаг гацаанд сүүлийн жилүүдэд баяжсан ардуудын нэг Цэрэндоржийнх 666 гектар бэлчээрийн талбай гэрээлэн авч 200 тонн тэжээл хураажээ. Түүнийгээ өвөл, хавар худалдаж 20 мянган юаний орлого олсон байна. Цэрэндорж ачааны машин, дунд гарын трактор, 3 өвс хадагч, хаман боогч машинтай юм<sup>7</sup>. Энэ мэтчилэн, үндэстний районуудад «түрүүлж баяжсан» ардууд олон байгаа боловч бүхэлд нь авч үзэх юм бол бас л ядуу зүдүү хүмүүс олонхи болсон хэвээр байна. Хятад биш үндэстний хүн амын 20 орчим хувь<sup>8</sup> буюу 15 сая хүний идэж уух, өмсөж зүүх асуудлыг хараахан шийдэж чадаагүй<sup>9</sup> байгаа нь өнөөгийн тулгам асуудал болж байна. Хятадын удирдлагаас үндэстний талаар явуулах бодлогодоо өөрчлөлт оруулаад 10 шахам жил болж байхад хятад бус үндэстний олон сая хүн ийнхүү наад захын хэрэгцээгээ ч хангаж чадахгүй гэдэс өлсгөлөн, ноорхой цоорхой хувцастай (жич: жилд нэг хүнд ногдох үр тараа 400 жин\*, цэвэр орлого 120 юаниас доош бол дээрх асуудлыг шийдвэрлэгдээгүй гэж үздэг байна. «Миньзу туаньзе», 1986 №6) амь зуусаар байгаа нь тэдний удаан жилийн хоцрогдол, ядуу дорой байдлыг ийм ч хялбар түргэн хувиргаж чадахгүйг гэрчилж байна.

Сүүлийн жилүүдэд Хятадын удирдлага үндэстний районуудад аж үйлдвэрийг хөгжүүлэх, ялангуяа тэндхийн байгалийн баялаг, түүхий эд, олон төрлийн ашигт малтмалын нөөцөөр илүү арвин байдлыг харалзан уул уурхайн болон ашигт малтмал олборлож боловсруулах үйлдвэр, цахилгаан эрчим хүч, хөнгөн ба хүнсний үйлдвэрийн салбаыг хөгжүүлэх талаар анхаарал тавих болов. Жишээлбэл, ӨМАР-ы нүүрсний нөөц 200 миллиард тонн бөгөөд 2000 он хүртэл Хятадад нээж ашиглах нүүрсний таван том ил уурхайн дөрөв нь Өвөр Монголд нээгдэх ажээ. Өнгөрсөн таван жилд Цинхай-Төвдийн цардмал зам, Өвөр Монголын Гуюань-Баошаний дулааны цахилгаан станц, Тунляогийн цахилгаан станц, Хоолин голын уурхай, Нинсягийн химийн завод, Урумчийн нефть-химийн үйлдвэр, Гуансигийн Дахуан усан цахилгаан станц зэрэг томоохон объектуудыг байгуулсан нь тус районуудын эдийн засгийн хүчин чадлыг үлэмж нэмэгдүүлэв.<sup>10</sup> 1980 онд үндэстний районуудад нийтдээ 37800 гаруй үйлдвэрийн газар байсан бол 1985 онд 43 мянга гаруй болсон бөгөөд тэдгээрээс нэлээд хэд нь орчин үеийн том хэмжээний үйлдвэрүүд юм. Өнгөрсөн таван жилийн эцэст аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 44,9 млрд. (тосгоны үйлдвэрийг оруулаад) юаньд хүрсэн нь 1980 оныхоос 70,5% нэмэгдэж жи-

6 «Жэньминь жибао» 1987. П 23.

7 «Китай», 1987. № 4. стр 5.

8 «Жэньминь жибао» 1986.V.16.

9 «Маньзу туаньзе». 1987, № 3, 7-р тал.

\*1 жин = 0,5 кг.

10 Beijing review» № 52 December 27, 1986, p. 24

лийн дундаж өсөлт нь 11,3% байв.<sup>11</sup> Гэвч одоо үндэстний районуудын аж үйлдвэрийн бүтээгдэхүүн Хятад улсын аж үйлдвэрийн нийт бүтээг дэхүүний дөнгөж 8%-ийг эзэлж<sup>12</sup>, үйлдвэрлэлийн хөгжлөөр тэдгээр район хоцрогдсон хэвээр байна.

Гадаадын капиталыг ихээр оруулж, шинжлэх ухаан техникийн тэргүүний ололт, үйлдвэрлэл эрхлэн хөтлөх арга туршлагыг суралцах гол зорилтыг агуулсан «нээлттэй хаалга»-ын бодлого үндэстний районуудад нэвтэрч, гадаадын пүүс компаниудтай гэрээ контракт тогтоож үйлдвэрийн газар хамтран байгуулах эхлэл тавигдаж байна. Гэтэл тэдгээр районууд нь далайн боомт гармаас алслагдсан, зам харилцаа саад бэрхшээлтэй, шинжлэх ухаан техникийн мэдлэг боловсролтой бсловсон хүчин дутмаг, ерөөс эдийн засгийн хөгжил нь сул дорой зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж төвийн бусад мужийг бодвол уул бодлогыг хэрэгжүүлж байгаа хэмжээ далайц явцуу, явц нь удаан байна. Харин тус районуудын гадаад худалдаа, жуулчлалын байгууллагын ажиллагаа жил ирэх бүр өргөжиж, түүний дотор Хилийн худалдаа сэргэн хөгжиж байна. Тухайлбал, ӨМАР-аас ЗХУ-тай хийж буй худалдааны хэмжээ өнгөрсөн жил 45 сая швейцар франкад хүрсэн бөгөөд 1985 оныхоос 9% өсчээ. Хятад, Зөвлөлтийн хилийн худалдааг 1983 онд сэргээсэн юм. Өнгөрсөн жил ӨМАР 147 сая ам.долларын бараа экспортлосон нь 1985 оныхоос 34 % илүү байна. Үүний 42 саяыг нь гадаадтай хамтарсан үйлдвэр, төлбөрийн худалдаа, түрээс, гадаад улсын зээллэг тусламжийн үндсэн дээр олжээ.<sup>13</sup> СУАР 1986 онд экспортоос 203 сая америк доллар олсон нь 1985 оныхоос 20% илүү байна. Тус автономит район гадаадын 70 орчим улс, районтой худалдааны харилцаатай бөгөөд ЗХУ, Пакистантай хилийн худалдаа хийж байна. Өнгөрсөн жил 169 сая ам. доллартай тэнцэх гадаадын хөрөнгө оруулсан нь 1981 — 1985 оны нийлбэр дүнгээс давав. Тус АР бас 20 сая ам. долларын өртөг бүхий техникийн импортын гэрээ байгуулжээ.<sup>14</sup> Мөн ТАР Балба, Бирм зэрэг хөрш орнуудтайгаа хилийн худалдаа хийж, гадаад дотоодын жуулчдыг олноор нь хүлээн авч байна.

Ийнхүү үндэстний районуудаас гадаад ертөнцтэй харилцах харилцаа цаашид өргөжих төлөвтэй байгаагийн зэрэгцээ тэдгээрийн үүд хаалгыг улс орныхоо дотоодод өргөн «нээж», хөгжингүй муж хотуудтай «эдийн засгийн шууд холбоо тогтоох нь түгжигдмэл, хагас түгжигдмэл үндэстний районуудын эдийн засгийг нээлттэй, таваарын аж ахуй болгон хөгжүүлэх урьдчилсан нөхцөл, тэрчлэн аж ахуйн системд хийх шинэтгэлийн чухал агуулга юм.»<sup>15</sup> гэж үзэж, түүнийг шургуу хэрэгжүүлж байна. Үүнтэй холбогдуулан хэдэн жишээ дурдвал, ӨМАР 1981 оноос эхлэн Хятадын дотоодын 200 гаруй районтай нийт дүнгээрээ 440 сая юаний өртөг бүхий эдийн засгийн хамтын ажиллагааны холбоо тогтоов. Эдийн засгийн хамтын ажиллагааны болон төрөл бүрийн мэргэжлийн 8 мянга гаруй техникийн ажилтан хүлээн авах 1300 гаруй гэрээ байгуулсан нь тус АР-ы эдийн засгийн хөгжилтөд багагүй түлхэц өгчээ.<sup>16</sup> НХАР тэргүүний техник технологи, үйлдвэрлэл эрхлэн хөтлөх туршлага нэвтрүүлснээр тус автономит районы аж үйлдвэр,

11 «Миньзу туаньзе». 1986. № 8, 22-р тал

12 «Миньзу яньзю» 1986. № 4. 20-р тал

13 «Та Кунг Пао» 5-11 February 1987 p. 4.

14 «Та Кунг Пао» 22—28. January 1987, p. 5

15 «Миньзу туаньзе» 1986. № 9. , 5-р тал

16 «Информационный бюллетень агентства Синьхуа», 27 апреля 1986 г.

тосгон суурины үйлдвэрийн бүтээгдэхүүний өртөг 30 сая, цэвэр ашиг нь 5 сая юаниар нэмэгдэв. Үйлдвэр, аж ахуйн газруудын хооронд холбоо тогтоож ажиллах явдал үр ашгаа өгч байна.<sup>17</sup> Жишээ нь, Өвөр Монголын Тунляогийн цахилгаан моторын үйлдвэр тоног төхөөрөмж, удирдлагын аргын талаар хоцрогдож олон жилээр хохиролтой ажилласан учир хаагдахад хүрч байв. Өнгөрсөн жил тус үйлдвэр Бээжингийн цахилгаан моторын үйлдвэртэй холбоо тогтоон ажилласнаар бүтээгдэхүүнийх нь чанар, үйлдвэрлэлээ удирдах түвшин нь дээшлэн сэргэн хөгжиж цэвэр ашиг нь 300 мянган юаньд хүрчээ.<sup>18</sup>

Далайн эрэг дагуу муж хотуудын дэвшилт техник, тоног төхөөрөмж үйлдвэрлэл эрхлэх туршлага үндэстний хоцрогдсон районуудад чухлын адил тус районуудын байгалийн баялаг, түүхий эдийн арвин баян нөөц, энэ талаар ихээхэн хомсдож байгаа бусад мужуудад зайлшгүй хэрэгтэй юм. Үүгээрээ дотооддоо «эдийн засгийн шууд холбоо» тогтоох буюу хоршин ажиллах нь чухал ач холбогдолтой ажээ. Энэ бодлогын хүрээнд дорно зүгийн «ах дүү мужууд»-аас инженер техникийн ажилтан, ажилчид мэдлэг туршлагаа заан сургахаар, таваарын аж ахуй хөгжүүлэхэд нь туслахаар, зарим иргэд худалдаа наймааны хэргээр үндэстний районуудад шилжин суурьших явдал өсөх хандлагатай байна.

Түүнчлэн, сүүлийн жилүүдэд Хятадын удирдах хүмүүс дээрх үндэстний районуудад удаа дараалан очиж, бодит байдалтай нь танилцан, засгийн газраас нь тэдэнд зарим хөнгөлөлт тусламж үзүүлж байна. Тухайлбал, сүүлийн 3 жилд эдгээр район нь төв засгийн газраас 12 миллиард гаруй юаний санхүүгийн тусламж, 1,2 миллиард гаруй юаний банкны зээл авчээ. Улсаас эдгээр районуудад зориулж их хэмжээний мөнгө тусгайлан олгосон байна.<sup>19</sup> Эдийн засаг, стратегийн талаар чухал ач холбогдолтой үндэстний районуудын ард түмнийг урьдын адил хавчин гадуурхаж, аж ахуй соёлын бүтээн байгуулалтыг нь огт хайхрахгүй байж болохгүйг ойлгосон Хятадын өнөөгийн удирдагчид үндэстний талаар явуулах бодлогодоо мэдэгдэхүйц өөрчлөлт оруулан нэлээд харж үзсэн Шинжтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж, нийт үндэстний районуудыг «Дөрвөн шинэчлэлт», «Хятадын өвөрмөц онцлогтой социализм» байгуулах зорилгод нийцүүлэн хөгжүүлэхийг байнга уриалж байна. Чухам ийм учраас Хятад улсын аж ахуйн системийг бүхэлд нь шинэтгэх бодлогод тус орны «салшгүй бүрэлдэхүүн хэсэг» болсон дээрх үндэстний районуудыг хамруулж байгаа юм. Сүүлийн жилүүдэд үндэстний районуудын эдийн засагт гарч буй ололт амжилтын тухай Хятадын хэвлэлд олонтаа бахархан тэмдэглэж буйн зэрэгцээ тэдгээрийн хөгжлийн хурдац бүх улсын дунджаас доогуур, хөгжингүй бусад мужуудтай харьцуулахад хөгжлийн түвшингийн зөрөөтэй байдал нь улам ихэсч байгааг мөн хүлээн зөвшөөрч байна. Ер нь үндэстний районуудын эдийн засагт зарим нааштай ахиц хандлага ажиглагдаж буй боловч урьдын бэрхшээл, аж ахуй, соёлын сул дорой бааз суурь нь өнөө хэр хэвээр оршин байгаа төдийгүй нийгэм, эдийн засгийн шинэ ноцтой асуудал, үр дагаврууд үүдэн гарсаар байна.

17 «Миньзу туаньзе». 1986. № 5, 32-р тал

18 Мөн тэнд

19 «Beijing review № 52, December 27, 1987, p. 24